

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГИЙН АНХДУГААР ХУРАЛ

1991 оны арванхоёрдугаар сарын эхээр БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны Академийн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хүрээлэнгээс санаачлан Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны иргэдийн нийгэмлэгийн анхдугаар их хурлыг Бээжин хотноо зохион байгуулж хийлгэв. Тус хуралд БНХАУ, Япон, БНСУ, БНАСАУ, БНМАУ, Оросын Холбооны улсаас 20 гаруй эрдэмтэн, мэргэжилтэн, нэрт эдийн засагчид оролцов.

Хуралдаанд оролцогсад Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааг өрнүүлэх чиглэлээр БНХАУ-ын тал санаачлага гаргасанд талархлаа илэрхийлээд энэ бүс нутгийн орнууд нягт хамтран ажиллахад эдийн засгийн иргэний хамтын ажиллагааг бүх салбарт өрнүүлэх явдал чухал ач холбогдолтой болохыг санал нэгтэй тэмдэглэжээ.

Хуралдаанаар бүс нутгийн орнууд хамтарсан үйлдвэр барих, хөдөө аж ахуйн салбарт хамтарч ажиллах, төмөр, авто зам тавих, далайн боомт ашиглах, газрын доорх баялгийг нээх, олон улсын соёлын тосгон байгуулах, цахилгаан эрчим хүчийг хөгжүүлэх, газрын тосыг хамтын хүчээр нээж ашиглах, орчин үеийн харилцаа холбоог хөгжүүлэх зэрэг эдийн засгийн гол гол салбарт хамтын ажиллагаагаа чиглүүлэхээр санал нэгтэй тогтов.

Хуралдаанаас хамтарсан хөрөнгийн сан бий болгох асуудал авч хэлэлцэв. Хамтарсан хөрөнгийн санг бүрдүүлэхдээ улс тус бүрийн эдийн засгийн хүчин чадал, нөхцөл боломжийг харгалзан үзэж тэгшитгэн хуваахаас аль болох зайлсхийх нь зүйтэй гэдэгт хуралд оролцогсад санал нэг байв. 1992 онд болох ээлжит хуралдаанаар энэ асуудлыг эцэслэн шийдвэрлэхээр тохиролцлоо.

Хятадын талын «Шанхайн бүс нутгийг хөгжүүлэх 30 чухал объект» гэдэг саналыг Япон, БНСУ-ын төлөөлөгчид нийтийн эрх ашгийг бодоогүй, хэт хувиа бодсон санал гэж шүүмжлэв. Монгол, БНАСАУ-ын

төлөөлөгчид ч уг шүүмжлэлийг дэмжсэнээр уг төсөл хойшлогдсон байна.

Японы төлөөлөгч Токио-Бээжин-Улаанбаатар-Оросын холбооны улсын алс дорнодыг холбосон төмөр зам тавих санал дэвшүүлж, хуралдаанд оролцогсад уг саналыг дэмжин цаашдын ажилд анхаарч үзэхээр болсон байна.

Хуралдаан дээр Япон, Өмнөд Солонгосын төлөөлөгчид Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Монгол улсын оролцоо нэн чухал ач холбогдолтой ба Монголд агаарын тээврийг хөгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэлээ. Мөн тэд Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжин, эдийн засгийнх нь байдал хүнд хэцүү байгаа энэ үед Зүүн хойт Азийн бүс нутгийн орнууд хөрөнгө, мөнгөний туслалцаа үзүүлэх явдал чухал байна гэдгийг хуралдаан дээр тодорхой ярьцгаасан байна. Энэ удаагийн хуралдаанар зохион байгуулалтын асуудал хэлэлцэж дарга, орлогч дарга, байнгын нарийн бичгийн дарга нарыг сонгов. Хүндэт даргаар Хятадын нэрт эдийн засагч Ма Хун (төрийн зөвлөлийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн судалгааны төвийн ерөнхий зөвлөх, хятадын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хүрээлэнгийн зөвлөх), даргаар Вэй Юймин (Хятадын Гадаад эдийн засгийн харилцааны яамны тэргүүн орлогч сайд, Хятадын хамтарсан үйлдвэрүүдийн удирдлагын нийгэмлэгийн дээд зэргийн зөвлөх) нарыг сонгож, гишүүн улс тус бүрээс орлогч дарга сонгов. Монголын талын дарга буюу нийгэмлэгийн орлогч даргаар профессор Ч. Далайг сонгов. Нийгэмлэгийн нарийн бичгийн даргаар БНСУ, БНАСАУ, Хятад гурван улсаас нэг нэг хүнийг сонголоо.

Хуралдаанаас Зүүн хойт Азийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн төвийг БНСУ-ын нийслэл Сеулд байрлуулахаар зарчмын хувьд тохиролцов. Байнгын гишүүдийн II их хурлыг 1992 оны 8 дугаар сард Пхеньян хотноо хийхээр санал нэгтэй тогтов. Тэр үеэр улс тус бүр үйлдвэр, худалдааны нэртэй мэргэжилтэн нараа дагуулан очиж, хамтран ажиллах тодорхой асуудлаар ярилцах нь зүйтэй гэж хуралд оролцогсад үзсэн байна. Дараагийн хуралдаанаас эхэлж АНУ-аас төлөөлөгч оролцуулж байхаар боллоо.

Хуралдаанд оролцсон орнууд Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгт чухал ач холбогдол өгч байна. Иймд манай улс энэ хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хэрэгтэй байна. Энд юуны өмнө эхний алхам болгож хөрөнгийн санд нь зохих хөрөнгө хандивлах явдал юм. Нөгөө талаар дээрх нийгэмлэгийн салбарыг Монголд нээж, хамтын ажиллагааны асуудлаар судалгаа хийж, мэдээлэл солилцох асуудлыг ч ойрын үед шийдвэрлүүштэй мэт санагдана.

С. Ариунсанаа

* * *

ХЯТАДЫН ХҮН АМ

1949 онд Хятад улс чөлөөлөгдсөнөөс хойш түүний хүн амын тоо нэг дахин нэмэгджээ. Одоо дундчаар жил бүр 10 сая гаруй хүн, сар бүр 1 сая 700 мянган хүн, долоо хоногт 380 мянган хүн, өдөрт 55 мянган хүн, цагт 1300 хүн, минутанд 38 хүн нэмэгдэж байна гэж тооцоолдог юм байна. Эдийн засгийн талаар тооцоолбол хүүхэд бүрийг 16 нас хүртэл тэжээхэд 300 юаниар бодож, өдөрт 40 мянган хүн нэмэгддэг

гэж үзвэл өдөр бүр 120 сая юань зарцуулна. Тэгвэл жилд 43 тэрбум 800 сая юань зарцуулах хэрэгтэй болно.

Хүн бүрийг жил бүр 300 кг хүнсний зүйлээр хангана гэж үзвэл хүүхэд бүрийг 16 нас хүртэл тэжээхэд 4800 кг хүнс тэжээл хэрэгтэй болох ажээ. Тэгвэл одоо өдөрт нэмэгдэж байгаа хүүхдийг 16 нас хүртэл тэжээхэд 192 сая кг хүнсний зүйлийг нөхөн хангах шаардлагатай болдог байна.

1949 онд Хятад улс чөлөөлөгдөх үед хятад улсын хүн амын тоо 600 сая байсан гэдэг бол одоо Хятад улсын хүн амыг 1 тэрбум 200 саяд хүрсэн гэж үздэг боловч үнэн чанартаа хятадын хүн амын тоо 1 тэрбум 400 саяд хүрчихсэн байна гэж зарим судлаачид тооцоолдог болов.

«Рэнь жай жоу бао» сэтгүүлийн 1990. 12. 20-ны өдрийн 51—0087 дугаараас авав.

Хятад хэлнээс орчуулсан Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан Г. Гунгаа

THE ISSUE IN BRIEF

QUESTIONS OF ECONOMIC DEVELOPMENT OF SOME NORTHEAST ASIAN COUNTRIES

D. Bayasgalan

In alignment with the rapid development of modern science and technology, interstate relations and cooperation are assuming diverse forms and one of them is regional cooperation. This form of cooperation not only shows mutually beneficial impact on interstate relations, but is also promoting the cause of integrating the world economy within a short spell of time.

The economic growth of the Asia-Pacific region and the Northeast Asia is mutually complementary and interconnected. This is why lately there is a growing interest to study the rapid development pace of the Asian -Pacific region and primarily of Northeast Asia.

Furthermore, Japan and South Korea in Northeast Asia, have higher rate, of development than any other country in the Asia-Pacific region and this fact is backed up by concrete facts and figures. The article also notes that Russia and China are conducting an economic reform and open-door policy, which create vast opportunities for the development of huge markets. The article also underlines that the foreign policy of Mongolia, which is making going towards market economy, is designed at developing bilateral and multilateral cooperation with the Northeast Asian countries and this policy is yielding tangible fruit.

MONGOL—JAPAN ECONOMIC RELATION

A. Buyantogs

This article is about the main important moments of the Mongolian-Japanese economic relationship in brief.

In 1991 the trade turn over between Mongolia and Japan has grown 19,2 times in comparison with 1972. The construction of Gobi cashmere plant in 1981 with the assistance of Japan has played an important role in increasing the export potential of Mongolia and developing the two countries relationship.

Today, Japanese government has been giving a great assistance in carrying out the economic reforms in our country.

The Mongolian-Japanese economic relations have the real foundation for future.

JAPANESE DEVELOPMENT EXPERIENCE

N. Dangaasuren

The Japanese people, basing on their mental development resources were able, first, to choose and assimilate technology and know-know of superior quality than any other country. Second, they started manufacturing their spare parts and entire machinery. Third, they were able to create machinery of much higher quality by mobilizing their intellectual potential. In order to reach this level of development, the Japanese, compared to other nations, utilized much more efforts and intellectual potential. The experience of Japan's development could be used by tailoring it to the specific conditions of Mongolia. This experience shows that the Mongolians can reach such a high level of development only by mobilizing their own efforts and resources. This article will show what Mongolia's «open-door policy» can and cannot accommodate. It is important to utilize effectively the growing relations between the two countries for mutually consolidating the sovereignty of Mongolia and Japan. In this connection, it is very important to make the best of the favourable international atmosphere here.

AMERICAN FARMS

Ts. Baatar

This article takes up in detail the question of farms, which is one of the basic agriculture production units in the United States. For example, form and size of farms, the peculiarities of their structural set up, and other matters have been dealt with in this article. The author basing on the works by researchers of the UN Food and Agricultural Organization and US scientists and utilizing the basic economic showings of American farms and other material, has outlined the present and future prospects of farms.

CONTEMPOREINTY AND TOURISM

D. Enhtaivan

Tourism developed only after World War Two and even then it occupies a very important place in the world economy today. Although the development level today varies from one country to another, the promotion of tourism is becoming an important lever of augmenting the material foundations of economy that particular country.

Today, foreign exchange revenues from tourism are growing faster than goods export revenues and they are able to complement within a brief spell of time investment. Moreover, tourism is not affected by protectionist measures practiced internationally.

If the country supports and promotes tourism, then it could become a positive factor of salvaging the economy of the country which is going downhill.

SÓVIET -JAPAN TERRITORIAL ISSUES

S. Ariunsanaa

Although 47 years have elapsed since the end of WWII and 36 years since end of the Soviet-Japan war and the signing of the joint declaration on the establishment of normal diplomatic relations, the two powerful neighbor countries have come to the threshold of the twenty first century without a peace treaty and without normal political and economic ties and relations. This is directly connected with the territorial disputes which existed and continue to exist between the Soviet Union and Japan.

Since extensive and precise research by a third part would be required for putting an end to this extremely complicated issue, the author has tried to present to the readers the conclusions and reasons provided by both sides to this issue.

In the present new stage of international relations, the solution of this issue will decided not only the political and economic cooperation matters between the Soviet Union and Japan but will also decide the future of the cooperation of the Northeast Asian and Asian-Pacific region, which are waiting for their era.

THE SHIVEIS ARE RELATED TO THE MONGOLS

A. Dashdemberel

There are only a few remaining people from the Shivei, but the Shiveis living in SUAR are continuing to use the Manchurian language even today, which they did in the ancient past.

From the early times, occidental and Mongolian historian have been closely studying the the Shivei tribes under the belief that they could be of Mongol origin.

These scholars, basing on the studies conducted by the contemporary Shiveis, support the idea that the Shiveis are of Mongol origin. But they conclude that the Shiveis could be of Manchu origin because they were the first from the Mongol tribes to secede and align with the Manchus. Their language is very close to ancient Mongolian language is proved by the name of people, places and ethnographical terms, and also their phrases and the grammatical structure of their language. Since the olden times, the Shivei's did not call themselves as Shivei but rather Sibey.

TRAVEL NOTES TO UPPER MONGOLIA

M. Zene

This article is designed at giving, though brief, understanding from first-hand source, about the past history, present situation, language, culture, religion and belief, customs and traditions and the peculiarities of life of the upper Mongols, who 300 years ago moved from the mainland Mongolia to settle in Hoh Nuur.

The article is divided into five parts: Brief History, Present Situation Gumbun-The Land of Gods, The Condition of Mongols and Tibetans and the Prospects of Cooperation.